



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2021.02.10 № 31648  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ НАРТ

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

Улсын онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн "Мэдээлэл, ажлын чиглэл хүргүүлэх тухай" 730 тоот албан бичгээр гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн өдрүүдэд тусгай зориулалтын автомашины хөдөлгөөнөөс бусад хөдөлгөөнийг бүрэн хориглосон тул Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газраас тусгай үйлчилгээний автобус шийдвэрлүүлж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглах чиглэл өгсөн.

Энэхүү асуудлаар Нийслэлийн нийтийн тээврийн газарт хандахад бүх төрийн албан хаагчдад зориулан 13 чиглэлд нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлэх болсон талаар мэдэгдсэн тул дараах асуудлыг анхаарч ажиллана уу. Үүнд:

1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн өдрүүдэд ажиллах өөрийн байгууллагын ажилтнуудад нийтийн тээврийн хэрэгсэл явах 13 чиглэлийн талаар мэдээлэх, байгууллагын цахим хуудас болон бусад дотоод мэдээллийн хэрэгсэлд нийтлэх;
2. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үед халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлах талаар анхааруулах;
3. Төрийн албан хаагчид ажлын үнэмлэхээ биедээ авч явах зайлшгүй шаардлагатай тул ажилтнуудын үнэмлэхний хугацааг сунгасан эсэхэд хяналт тавих. Мөн ажилтнуудад нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо U-Money картаа ашиглах талаар мэдэгдэх;

Төрийн албан хаагчдад үйлчлэх нийтийн тээврийн маршрутыг хавсралтаар хүргүүлж байна. Түүнчлэн маршрут, тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг [www.transport.ub.gov.mn](http://www.transport.ub.gov.mn) цахим хуудаснаас үзэж боломжтой

Хавсралт: Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн өдрүүдэд үйлчлэх нийтийн тээврийн маршрут. 13 хуудас

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ П.ЭРХЭМБУЛГАН

